

СЭНДБОКСЫН ОРЧНЫ ТОЙМ

2024 оны III улирал

АГУУЛГА

НЭГ.	СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	3
1.1	B2B зээлийн үйлчилгээ	3
1.2	Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ	4
1.3	Хамтын санхүүжилтийн үйлчилгээ	6
1.4	P2P зээлийн үйлчилгээ	7
1.5	Блокчэйн арилжааны систем	9
ХОЁР.	БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ	10

ХОЛБОО БАРИХ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР,
СЭНДБОКСЫН АЛБА

УТАС: 51-261106

И-МЭЙЛ: SANDBOX@FRC.MN

ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН IV БАЙР, БАГА ТОЙРУУ 3,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, УЛААНБААТАР ХОТ, 15160

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Сэндбоксад ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 23* хүсэлт ирсэн бөгөөд үүнээс 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 3 хүсэлт шинээр ирсэн байна.



B2B зээлийн үйлчилгээ

B2B зээлийн үйлчилгээ нь 2024 оны нэгдүгээр сард сэндбоксын орчинд орсон. Тус үйлчилгээ нь аж ахуй нэгжүүдийн богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээг хангах, байгууллагуудын харилцах дансанд буй илүүдэл нөөцийг эргэлтэд оруулах замаар зах зээл дэх эх үүсвэрийг үр ашигтайгаар ашиглах боломжийг олгох юм.



128

Бүртгэлтэй
харилцагч

32.5 тэрбум

B2B зээлийн
олгосон дүн



B2B зээлийн үйлчилгээ нь 2024 оны хоёрдугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар тус платформд бүртгэлтэй 128 харилцагч байна. Платформоор нийт 32.5 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 27.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Мөн B2B зээлийн дундаж хүү 1.5 хувьтай байгаа бол хугацааны хувьд 14, 21, 28 гэсэн хоногуудтай байна.



B2B зээлийн хугацаа

14, 21, 28 хоног



B2B зээлийн дундаж хүү

1.5%

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021 оны 12 дугаар сард сэндрокс орчинд орсон бөгөөд мөнгөний захад хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, факторинг (хямдруулсан нэхэмжлэл), итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэх төлбөр тооцоо, бүртгэл, хадгалалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн туршиж байна.

Хадгаламжийн сертификат

2023 оны 9 дүгээр сараас эхлэн Хадгаламжийн сертификат арилжаалагдаж эхэлснээс хойш 2024 оны 3 дугаар улирлыг хүртэлх байдлаар нийт 108.9 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Анхдагч
арилжааны дүн

96.8 сая

Хоёрдогч
арилжааны дүн

12.1 сая

Итгэлцэл



2023 оны 10 дугаар сард Итгэлцлийн арилжааг шинээр эхлүүлснээс хойш 2024 оны 3 дугаар улирлыг хүртэлх байдлаар нийт 3.4 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээг зуучилсан байна.

р Анхдагч
арилжааны дүн

2.7 тэрбум

Хоёрдогч
арилжааны дүн

788 сая



Худалдагч



1,383

удаагийн хэлцэл



Платформ

Худалдан авагч



282.7 тэрбум
төгрөгийн арилжаа

Репо хэлцэл зуучлалын платформ дээр өнгөрсөн хугацаанд 41 зээлдүүлэгч, 32 зээлдэгч нийт 282.7 тэрбум төгрөгийн 1,383 удаагийн арилжаа хийсэн байна. Мөн 2024 оны 3 дугаар улиралд мөнгөний зах нь нийт 63 удаагийн 16 тэрбум төгрөгийн илүүдэл нийлүүлэлт, 7 удаагийн 2.2 тэрбум төгрөгийн илүүдэл эрэлттэй байсан. Репо хэлцлийн платформоор хийгдэж буй зээлийн дундаж хугацаа 42 хоног, харин репо зээлийн дундаж хүү 17.8 хувьтай байна.



Репо зээлийн дундаж хүү

17.8%

Репо зээлийн дундаж хугацаа 42 хоног



7 хоног

14 хоног

28 хоног


84 хоног

Хүснэгт . Мөнгөний захын ерөнхий үзүүлэлтүүд

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
2022 III улирал	13	14	164	24,280,000,000	21.4	26
2023 III улирал	16	20	140	30,840,000,000	18.4	35
2024 III улирал	18	20	114	27,310,000,000	17.87	42

2024 оны 3 дугаар улирлын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад арилжааны тоо 26-аар, нийт арилжааны дүн 11 хувиар, жилийн жигнэсэн дундаж хүү 0.5 пунктээр буурсан байна.

Зураг. Мөнгөний захын хүүгийн түвшин ба арилжааны дүн, репо зээлийн хугацаагаар



Мөнгөний захын 3 дугаар улирлын хүүгийн түвшин болон арилжааны дүнг харуулав. 2024 оны 3 дугаар улиралд мөнгөний зах дээр хийгдсэн нийт репо хэлцлийн дүн өмнө жилийн мөн үетэй харьцуулахад 11 хувиар буурч, 27.3 тэрбум болсон байна. Өмнө онуудын 3 дугаар улиралд хийгдсэн нийт репо хэлцлийн 66.7 хувийг 4 долоо хоногийн хугацаатай, 20.3 хувийг 12 долоо хоногийн хугацаатай, 11.5 хувийг 2 долоо хоногийн хугацаатай, 1.5 хувийг 1 долоо хоногийн хугацаатай репо хэлцлүүд тус тус эзэлж байна.

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь 2022.12.30–ны өдрөөс эхлэн сэндрбоксын орчинд орж хамтын санхүүжилтийн үйлчилгээ буюу краудфандинг үйлчилгээгээ туршиж байна. Одоогоор 2 байгууллага сэндрбоксын орчинд урамшуулал, зээл, хувьцаа, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.




2024 оны 3 дугаар улирлын байдлаар урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн 31 төсөлд 2,934 хөрөнгө оруулагчаас нийт 220.8 сая төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлснээс 212.3 сая төгрөгийн урамшуулалт санхүүжилтийн төсөл амжилттай хэрэгжсэн. Төслүүдийн хувьд дунджаар нийт шаардлагатай санхүүжилтийн 30.4 хувийг босгосон байна.

Платформоор санхүүжилт босгосон эдгээр 31 төслийн 21 төсөл нь 1 сараас бага хугацаатай төслүүд бөгөөд төслийн дундаж хугацаа 31 хоног байна.

Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн 14 төсөл нийтлэгдсэн бөгөөд нийт 1524 оролцогчоос 51.1 сая төгрөгийн хандивыг босгосон.


Зээлд суурилсан Зээлийн 1 төсөл хэрэгжиж 2 хөрөнгө оруулагчаас 11 сая төгрөгийн санхүүжилт босгосон байна.



Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 65.3 хувь нь 18–35 нас, 22.6 хувь нь 36–45 нас, 8.3 хувь нь 46–55 нас, 3.8 хувь нь 55–аас дээш насныхан байна.

P2P зээлийн үйлчилгээ


P2P зээлийн үйлчилгээ нь 2022 оны 12 дугаар сард Сэндбоксын орчинд орсон бөгөөд Сэндбокс зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг гаргаж тус хүсэлтийн дагуу 2024 оны Санхүүгийн зохицуулах хорооны даргын 33 дугаар тушаалаар сэндбоксын хугацааг сунган хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээг хөгжүүлэн хоёр дахь жилдээ туршиж байна.



98.7% зээлдэгч **1.3%** хөрөнгө оруулагч

2024 оны 3 дугаар улирлын байдлаар тус платформоор 8,860 харилцагч P2P зээлийн үйлчилгээг хүртжээ. Эдгээр харилцагчдын 1.3 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 98.7 хувь нь зээлдэгч байна.

Платформоор нийт 2.9 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс P2P-ийн зээлийн үлдэгдэл 408 сая төгрөг байна. Мөн олгосон зээлийн багцын 76.4 хувийг 3 сараас бага хугацаатай, 14.8 хувийг 4–6 сарын хугацаатай, 8.8 хувийг 7–9 сарын хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 42.0 хувийг 1 жилийн хугацаатай, 58.0 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.



P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 97.9 хувь нь хэвийн, 1.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 0.5 хувь нь чанаргүй гэсэн тус тус ангилалтай байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2 хувь байна.

ЭМЭГТЭЙ



64.8%

ЭРЭГТЭЙ



35.2%

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 64.8 хувь нь эмэгтэй, 35.2 хувь нь эрэгтэй байна. Харин нийт харилцагчдын 50.0 хувийг 18–35 насныхан, 34.5 хувийг 36–45 насныхан, 12.6 хувийг 46–55 насныхан, 2.9 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 62.1 хувь нь дээд, 4.1 хувь нь тусгай дунд, 29.3 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь дунд, 0.3 хувь нь бага боловсролтой байна.

Насны бүлгээр

18–35 нас



50%

36–45 нас



34.5%

46–55 нас



12.6%

55–аас дээш



2.9%

Боловсролын түвшнээр



Дээд

Тусгай
дундБүрэн
дунд

Дунд

Бага

62.1%

4.1%

29.3%

4.2%

0.3%

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Блокчэйн арилжааны систем

Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем нь 2024 оны 11 дүгээр сараас эхлэн сэндбоксын орчинд орсон. Биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн системийг нэвтрүүлснээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, цагийн хязгаарлалтгүй 24/7 гүйцэтгэх боломж бүрдэх юм.




Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем нь 2024 оны 4 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар тус платформуор нийт 92,480 ширхэг үнэт цаас 9.3 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан байна. Мөн бондын жигнэсэн дундаж хүү 21.5%-тай байна. Блокчэйн хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцсон 4 шууд оролцогч байна.


Блокчэйн системийн хоёрдогч арилжаанд 2 үнэт цаас гаргагч бонд гаргасан ба бондын санхүүжилтийг зээлийн багц нэмэгдүүлэхэд зарцуулахаар төвлөрүүлсэн байна.

Блокчэйн системийн арилжааны эзлэх хувь


Тайлант хугацаанд биржийн бус зах зээл дээр хийгдсэн нийт арилжааны 65.0 хувийг анхдагч зах зээлийн арилжаа, 34.0 хувийг уламжлалт хэлбэрээр гүйцэтгэсэн хоёрдогч зах зээлийн арилжаа, 1.0 хувийг блокчэйн систем дээр хийсэн хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.



Үнэт цаас гаргагч



ОТС
ПЛАТФОРМ



Хөрөнгө оруулагч

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Зохицуулалтын орчныг сайжруулах ажлын хүрээнд:

“Азийн Хөгжлийн Банк (АХБ)”-ны санхүүжилттэй “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр төсөл” **(1)** Монголын финтек, инновацын экосистемийг хөгжүүлэх замын зургийг боловсруулах, **(2)** Санхүүгийн хяналт, шалгалтад суптекийг нэвтрүүлэхэд шаардлагатай үнэлгээний болон бодлогын зөвлөмжийн тайланг боловсруулах, зорилготойгоор 2025 оныг хүртэл хэрэгжих ба төслийн үндсэн хэрэгжүүлэгчээр Санхүүгийн зохицуулах хороо, хамтран хэрэгжүүлэгчээр Монголбанк, Сангийн яам ажиллаж байна.

Сэндбоксыг зохицуулалтын орчны журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Сэндбоксын орчныг олон нийтэд таниулах ажлын хүрээнд:

Авлигатай тэмцэх газрын албан хаагчдад “Сэндбоксыг зохицуулалт” сэдэвт сургалт, олон нийтийн санхүүгийн боловсролд зориулсан хөрөнгийн зах зээлийн анхан шатны сургалтад “Эдийн засгийн үндсэн ойлголтууд, санхүүгийн зах зээл” сэдэвт сургалт орсон.

МҮЦАЭХ-ноос зохион байгуулдаг атестатчлалын сургалтад “Сэндбоксыг зохицуулалт”, Харилцаа холбооны зохицуулах газарт “Сэндбоксыг зохицуулалтыг нэвтрүүлсэн туршлага” хуваалцсан.


Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын холбооноос зохион байгуулсан хурлуудад 7, 9р сард зочин илтгэгчээр оролцон “Монгол Улс дахт финтекийн салбарын нөхцөл байдал, сэндбоксыг зохицуулалт”-ын талаар хуваалцсан

JCI нийгэмлэгээс зохион байгуулсан үндэсний чуулганд “Санхүүгийн зах зээл дэх технологийн хөгжил” сэдэвт сургалтыг орсон.

“Финтекийн форум-2024”-т панелистээр оролцон сэндбоксыг зохицуулалтын талаар мэдээлэл олон нийтэд өгсөн.


Сэн

2024 оны III улирлын байдлаар Сэндбоксыг орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 31 компанитай 76 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.



Сэндбоксыг туршигдаж буй 6 бүтээгдэхүүн тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягыг боловсруулан 7 хоног, сар, улирлын тайлан, мэдээг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг мөн гүйцэтгэн ажиллаж байна.



Сэндбоксыг туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

Финтекийн хөгжил болон зохицуулалтын орчны талаарх цахим болон танхимын сургалт, уулзалтуудад тогтмол оролцож байна.



